



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Улсын Их Хурлын саналын дагуу хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаа



**Тогтвортой байдлын гэрээг тооцоо муутай
хийснээс ашигт малтмалын ордын стратегийн ач
холбогдол алдагдаж байна**



Улаанбаатар 2007 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Хоёрдугаар газар

Газрын захирал
О.Мэндбаяр

Аудитын менежер
Х.Баярмаа

Ахлах аудитор
Б.Сугар

Аудитор
С.Оюунгэрэл

Шинжээч
Ц.Цэрэнхүү

Шинжээч
Б.Болормаа

2007 оны 6 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү:

www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 263813 дугаарын утас,
323266 дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс

Товчилсон үгийн жагсаалт 2

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй .. 3

Бүлэг 1

Холбогдох хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэхгүй байна

- Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон орд газарт хайгуулын тусгай зөвшөөрөл олгож хууль зөрчжээ 5
- Улсын төсвөөс хайгуулын ажилд гаргасан зардлыг нөхөн төлөх гэрээгүйгээр олборлолт хийж байна 7
- Хайгуулын болон ашиглалтын ажил төлөвлөсөн хэмжээнд хийгдээгүй байна 9
- Мэдээ, тайланг хугацаанд нь бүрэн ирүүлээгүй байна 9
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нар байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэхгүй байна 10
- Шалгалтаар ногдуулсан торгууль, төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна 11

Бүлэг 2

Тогтвортой байдлын гэрээ тооцоо муутай хийгджээ

- Тогтвортой байдлын гэрээ байгуулахдаа эдийн засгийн тооцоо, дүн шинжилгээ сайтар хийж чадаагүй байна 12
- Тогтвортой байдлын гэрээнээс хамаарч аж ахуйн нэгжүүдийн татвар төлөлт жигд бус байна 14

Зөвлөмж 19

Хавсралт.....20

Холбогдох байгууллагын санал.....24

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЭЗЯ	Санхүү, эдийн засгийн яам (хуучин нэрээр)
ҮХЯ	Үйлдвэр, худалдааны яам
БОЯ	Байгаль орчны яам
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
АМХЭГ	Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар (хуучин нэрээр)
ГУУКА	Геологи, уул уурхайн кадастрын алба
ҮТЕГ	Үндэсний татварын ерөнхий газар
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
ГУУХА	Геологи, уул уурхайн хяналтын алба
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ЭХСХТ	Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
ОСИТБС	Олборлох салбарын ил тод байдлын санаачилга
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

УИХ-ын санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд энэхүү аудитыг хийв.

Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн зарим үйл ажиллагааг шалгаж, дүгнэлт гаргах, үр ашгийг дээшлүүлэх санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газарт тусгай зөвшөөрөл эзэмшигч 30 орчим хуулийн этгээдийн 2006 онд гүйцэтгэсэн геологи хайгуулын болон олборлолтын үйл ажиллагааны тайлан мэдээ, холбогдох санхүүгийн баримтуудыг шалгав. Харин ГУУКА-д шинэчилсэн бүртгэл хийлгэж тусгай зөвшөөрөл авсан боловч тэмдэглүүлсэн хаягаар байхгүй, утасны дугаар нь өөрчлөгдсөн 10 гаруй аж ахуйн нэгж, хуулийн этгээдийг олж, шалгаж чадаагүй болно.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн шалгалтын журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг мөрдлөг болгон АМГТХЭГ-ын мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын багийн мэргэжлийн шинжээчээр ШУТИС-ийн профессор Д.Дондов ажиллалаа.

Бүлэг 1

Холбогдох хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэхгүй байна

1.1 УИХ-аас 2006 онд баталсан Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.11-т “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэж үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг хэлнэ” гэж заасан.



1.2 УИХ-ын 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 27 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон нэр бүхий 14 орд, мөн хувийн хөрөнгөөр хайгуул хийгдэж байгаа Оюутолгойн зэсийн орд, нийт 15 ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газарт хамруулан баталжээ. Үүнд:

д/д	Ордын нэр	Ашигт малтмалын төрөл	Байршил	
			Аймаг	Сум
1.	Таван толгой	Чулуун нүүрс	Өмнөговь	Цогтцэций
2.	Нарийн сухайт	Нүүрс	Өмнөговь	Гурвантэс
3.	Багануур	Хүрэн нүүрс	Улаанбаатар	Багануур
4.	Шивээ Овоо	Хүрэн нүүрс	Говьсүмбэр	Шивээговь
5.	Мардай	Уран	Дорнод	Дашбалбар
6.	Дорнод	Уран	Дорнод	Дашбалбар
7.	Гурван булаг	Уран	Дорнод	Дашбалбар
8.	Төмөртэй	Төмрийн хүдэр	Сэлэнгэ	Хүдэр
9.	Оюу толгой	Зэс, молибдени	Өмнөговь	Ханбогд
10.	Цагаан суварга	Зэс, молибдени	Дорноговь	Мандах
11.	Эрдэнэт	Зэс, молибдени	Орхон	Баян-Өндөр
12.	Бүрэнхаан	Фосфорит	Хөвсгөл	Алаг- Эрдэнэ
13.	Бороо	Алт	Сэлэнгэ	Баянгол
14.	Төмөртэйн овоо	Цайр, хар тугалга	Сүхбаатар	Сүхбаатар
15.	Асгат	Мөнгө	Баян-Өлгий	Ногооннуур

1.3 Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд хайгуулын болон ашиглалтын ажлыг үнэт металл (алт, мөнгө), өнгөт металл (зэс, цайр, полиметалл), шатах ашигт малтмал (нүүрс), ховор металл (цагаан тугалга, гянтболд), хар металл (төмөр), металл бус (хайлуур, шохойн чулуу) зэрэг ашигт малтмалуудаар голлон явуулж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон орд газарт хайгуулын тусгай зөвшөөрөл олгож хууль зөрчжээ

1.4 Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 14 ордын тусгай зөвшөөрлүүдийг АМГТХЭГ-ын ГУУКА 1997 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу олгожээ.



1.5 Харин Таван толгойн нүүрсний ордоос солбицол бүхий газрыг Үйлдвэр худалдааны сайдын 2006 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 17 дугаар тушаалаар 6 сарын хугацаагаар нөөцөд авсан байна. Нөөцөд авсан тухайн талбайд “Энержиресурс” ХХК ашиглалтын тусгай зөвшөөрөл авахаар 2006 оны 7 дугаар сарын 8-нд өргөдөл өгснийг ГУУКА-ны өргөдлийн бүртгэлийн 17967А дугаарт бүртгэжээ.

1.6 ГУУКА-ны мэргэжилтэн тухайн өргөдөлд шүүлт хийж, хүсэлт гаргасан талбайн солбицол дээрх тушаалаар нөөцөд авсан болон 287А дугаартай лицензийн талбайтай хэсэгчлэн давхцаж байгааг тогтоож, энэ тухай тэмдэглэсэн боловч ГУУКА-ны дарга 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 7-3194 дүгээр албан бичгээр “. . . дээрх талбайг танай компанид олгох боломжтой байна” гэсэн хариуг “Энержиресурс” ХХК-д өгсөн байна.

1.7 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу Таван толгойн нүүрсний орд газарт ашиглалтын үйл ажиллагаа явуулах талаар Өмнөговь аймгийн тухайн үеийн удирдлагаас санал авахад 2006 оны 8 дугаар сарын 2-ны 27 дугаар албан бичгээр “Дэмжинэ” гэсэн саналыг ГУУКА-нд ирүүлжээ. Гэтэл АЗДТГ-ын архивт “Дэмжихгүй” гэсэн утга бүхий албан бичиг хадгалагдаж байна.

1.8 “Дэмжинэ” гэсэн энэхүү санал болон компаний өргөдлийг үндэслэн ГУУКА-ны дарга асан Т.Занаширийн 2006 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 805 дугаар шийдвэрээр Энержиресурс компанид 2135 га талбайн 11943А дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон нь тусгай хэрэгцээний газар нутаг, талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан тохиолдолд хүсэлт гаргасан талбайг олгохоос татгалзаж, тухайн өргөдлийг бүртгэлээс хассанд тооцох тухай Ашигт малтмалын тухай хуулийн (1997 оны) 14.9.2 дахь заалтыг зөрчсөн байна.

1.9 ГУУКА-ны даргын 2006 оны 8 дугаар сарын 28-ны 855 дугаар шийдвэрээр уг талбайн солбицолд өөрчлөлт оруулж, давхацлыг арилгах зохицуулалт хийжээ.

1.10 Дээр дурдсан шийдвэрүүдийг УМХГ-ын ГУУХА-наас шалгаад “Ашигт малтмалын тухай (1997 оны) хуулийн 13, 14 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг зөрчиж олгогдсон 11943А дугаар лицензийн талбайд уг хуулийн 48 дугаар зүйлийн 4 дэх заалтын дагуу өөрчлөлт оруулж хуульд нийцүүлэх нь зүйтэй” гэсэн улсын байцаагчийн 2006 оны 11 дүгээр сарын 8-ны 09/67/447 дугаар дүгнэлт бичигджээ. Үүний дагуу сонгон шалгаруулалт дахин хийх шаардлагатай байна.

1.11 2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1-д заасны дагуу АМГТХЭГ-ын ГУУКА тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэлийг шинэчлэх ажлыг 2006 оны 8 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн хийж байна.

1.12 Шинэчлэн баталсан Ашигт малтмалын тухай хуулийн 60.4-д “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг тогтоон улсын бүртгэлд бүртгэсэн ордод

хайгуулын тусгай зөвшөөрөл олгохгүй”, Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5-д “2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн ордод хайгуулын тусгай зөвшөөрөл (лиценз) авсан этгээд өргөдөл гаргавал шинэ хуулийн дагуу түүнд ашиглалтын зөвшөөрөл олгоно” гэж заасныг зөрчин 18 хуулийн этгээдийн 34 хайгуулын тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгэжээ. (Хавсралт №1)

1.13 Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 18 хуулийн этгээдээс Тефис майнинг ХХК, Бороо гоулд ХХК, Сентеррагоулд ХХК, Юү Жи Эл интерпрайзис ХХК, Вестерн проспектор монголия ХХК, Эмээлт майнз ХХК, Ханресорсез ХХК болон Хөх тэнгэр тур компани хайгуулын ажлыг гүйцэтгэж, үлдсэн 10 нь 1-5 жил үйл ажиллагаа огт явуулаагүй байна.

1.14 АМГТХЭГ улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон нэг ч ордын хил хүрээг геологи-уул уурхайн кадастрын зурагт оруулах ажлыг хийгээгүйгээс бүртгэлийг шинэчлэх ажил хуулийн дагуу хийгдээгүй байна.

1.15 Аудитын явцад стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 14 ордын хил хүрээг геологи-уул уурхайн кадастрын зурагт буулгасан анхны хувилбарыг Геологийн мэдээллийн төвөөр гаргууллаа.

Уг зургийг үндэслэн гаргасан судалгаагаар тусгай зөвшөөрөл, түүнийг эзэмшигчдийн тоог орд тус бүрээр харуулбал:

д/д	Ордын нэр	Тусгай зөвшөөрлийн тоо			Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тоо		
		Хайгуул	Ашиглалт	Нийт	Хайгуул	Ашиглалт	Нийт
1	Таван толгойн нүүрсний орд	-	10	10	-	4	4
2	Нарийн сухайтын нүүрсний орд	-	6	6	-	1	1
3	Багануурын нүүрсний орд	2	1	3	2	1	3
4	Шивээ Овоогийн нүүрсний орд	7	1	8	3	1	4
5	Мардайн ураны орд	1	-	1	1		1
6	Дорнодын ураны орд	2	1	3	2	1	3
7	Гурван булагийн ураны орд	3	1	4	2	1	3
8	Сэлэнгийн Төмөртэйн төмрийн хүдрийн орд	-	4	4	-	3	3
9	Оюу толгойн зэс молибдений орд	-	1	1	-	1	1
10	Цагаан суваргын зэс молибдений орд	2	1	3	1	1	2
11	Эрдэнэтийн зэс молибдений орд	-	2	2		2	2
12	Бүрэнхааны фосфоритын орд	10	5	15	5	3	8

13	Бороогийн алтны орд	6	20	26	3	3	6
14	Төмөртэйн овооны цайрын орд	1	1	2	1	1	2
15	Асгатын мөнгөний орд	-	3	3	-	1	1
	Дүн	34	57	91	20	24	44
Тайлбар: Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг давхар эзэмшигч хуулийн этгээд							4

1.16 АМГТХЭГ-ын ГУУКА-аас стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 15 орд газарт 40 хуулийн этгээдэд хайгуулын 34, ашиглалтын 57, нийт 91 тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгожээ.

1.17 Стратегийн ач холбогдол бүхий нэг орд газарт дунджаар 1-8 хуулийн этгээд 2-26 тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа нь ихээхэн хөрөнгө оруулалт шаарддаг геологи, уул уурхайн үйлдвэрлэлийн цогц үйл ажиллагаа явуулах боломжийг хомс болгож, нэг нь нөгөөдөө саад болох нөхцөлийг бүрдүүлжээ. Тухайлбал, Шивээ-Овоо ХК-ний уурхайн одоогийн ашиглалтын талбай болох 91 га газрыг тойруулан “Шинэ Шивээ”, “Аргамгаг трейд”, “Дуулгат халиун” зэрэг компаниудад хайгуулын тусгай зөвшөөрөл олгосноос ашиглалтын талбайг өргөтгөх боломжгүй болсон байна. Түүнчлэн Эрдэнэт үйлдвэр, Багануур ХК, Таван толгой ХК-иуд цаашид үйл ажиллагаагаа өргөтгөхөд бэрхшээл учрах нөхцөл бүрджээ.

1.18 Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 24 хуулийн этгээдээс одоогоор 8 хуулийн этгээд, тухайлбал, Эрдэнэт үйлдвэр, Багануур ХК, Бороогоулд ХХК, Цайрт минерал ХХК, Таван толгой ХК, Шивээ овоо ХК, Чинхуа-МАК Нарийн сухайт ХХК болон Төмөртэйн хүдэр ХХК орд ашиглах үйл ажиллагаа явуулж байна.

1.19 Төмөртэйн хүдэр компани 2006 оны 8 дугаар сараас хойш үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмших эсэх нь шүүхээр шийдвэрлэгдэхээр хүлээгдэж байна.

1.20 Айвенхоу майнз Монголия инк компани хайгуулын ажлыг дуусгаад уул уурхайн үйлдвэрлэл явуулах, барилга угсралтыг эхлүүлэх бэлтгэл хийж байна.

1.21 Тавантолгойн нүүрсний орд газарт Энержиресурс ХХК-д хууль зөрчин олгосон 11943А дугаартай лицензийн талбайгаас 101 га талбайг Дайцүки ХХК-д ГУУКА-ны даргын 2006 оны 9 дүгээр сарын 1-ний 891 дүгээр шийдвэрээр шилжүүлжээ. Ийнхүү хууль зөрчиж Энержиресурс ХХК, Дайцүки ХХК-д олгосон эдгээр ашиглалтын тусгай зөвшөөрлийг хянан үзэж, зохих журмын дагуу шийдвэрлэх шаардлагатай байна.

Улсын төсвөөс хайгуулын ажилд гаргасан зардлыг нөхөн төлөх гэрээгүйгээр олборлолт хийж байна

1.22 Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн (1997 оны) 7-д “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийгдсэн орд газраас олборлолт явуулж буй лиценз эзэмшигч улсын төсвөөс хайгуулын ажилд гаргасан зардлыг Ашигт малтмалын тухай хууль хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн хугацаанд тогтмол хэмжээгээр улсын төсөвт буцааж төлнө” гэж заажээ.



1.23 Дээрх заалтад үндэслэн Засгийн газрын 1997 оны 234 дүгээр тогтоолоор “Төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын хэмжээг шинэчлэн тогтоох, төсөвт нөхөн төлөх журам”-ыг баталжээ. Ашигт малтмалын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан уг журмыг Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан байна.

1.24 АМГТХЭГ аудитад хамрагдсан 15 ордыг ашиглах тусгай зөвшөөрөлтэй 24 хуулийн этгээдээс 6 ордод тусгай зөвшөөрөл эзэмшигч 6 хуулийн этгээдтэй хайгуулын ажлын зардлыг нөхөн төлүүлэх гэрээ байгуулсан байна. Тухайлбал:

Хуулийн этгээдийн нэр	Тусгай зөвшөөрлийн		Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын зардал (ам.доллар)			Тайлбар
	Дугаар	Талбайн хэмжээ /га/	Гэрээгээр тогтоосон	Төлөлт	Үлдэгдэл	
“Монголын алт-МАК” ХХК	9630А	132	714760	714760		
Чинхуа-МАК Нарийн сухайт ХХК	5458А	131	5460	5460		Дутуу тооцсон байна
“Багануур” ХК	1371А	1445	94694	18939	75755	Төлөх хугацаа хэтэрсэн
“Бороогоулд” ХХК	Шороон орд		170118	170118		
	Үндсэн орд		2387046	1670935	716111	Гэрээний хугацаандаа
“Төмөртэйн хүдэр” ХХК		1200	667522	75522		Гэрээний хугацаандаа
“Цайрт минерал” ХХК	723А	38	571000*	228400	342600	Гэрээний хугацаандаа

1.25 Монгол-Германы хамтарсан Салхитын экспедици Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Төмөртийн овооны цайрын ордын районд 1973-1979 онд хайгуул хийж, нийт 10717,8 мянган шилжих рублийн зардал гаргаснаас Төмөртийн овооны цайрын ордод 5311,0 мянган шилжих рубль зарцуулжээ.

1.26 Энэхүү зардлыг үндэслэн нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо СЭЗЯ-ны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын орлогч дарга асан Х.Хурметханы 2000 оны 10 дугаар сарын 4-нд АМХЭГ-т ирүүлсэн 016/334 дугаар албан бичигт “Шилжих рублийн төгрөгтэй харьцах ханшийг албан ёсоор тогтоогоогүй тул 1970-1990 оны хооронд хийгдсэн геологи хайгуулын ажлын нөхөн төлбөрийг тооцохдоо уг ажлын хэмжээг өнөөдрийн зардлын нормативаар үржүүлэх замаар тодорхойлох нь зүйтэй” гэснийг баримтлан тооцсон нь Засгийн газрын 1997 оны 234 дүгээр тогтоолыг зөрчсөн байна.

1.27 Монгол Банкнаас АМГТХЭГ-т 2007 оны 1 дүгээр сарын 30-нд ирүүлсэн 5/172 дугаар албан бичгийн хавсралтаас үзэхэд 1990 оноос өмнөх рублийн төгрөгтэй харьцах ханш тогтвортой 4,18 байсан бөгөөд энэ ханшаар дээрх тогтоолын дагуу тооцоход 1005936 ам.долларын зардал нөхөн төлүүлэх байжээ.

1.28 Гэтэл тухайн үеийн СЭЗЯ, АМХЭГ гэрээг 571000 ам доллараар хийсэн нь Засгийн газрын тогтоолыг зөрчиж, төлбөрийн хэмжээг 434936 ам доллараар бууруулсан байна. Иймд энэхүү зөрчлийг арилгаж, зөрүүг нөхөн төлүүлэх, гэрээний холбогдох заалтыг өөрчлүүлэх нь зүйтэй байна.

1.29 Өмнөговь аймгийн Нарийн сухайтын нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч Чинхуа-МАК Нарийн сухайт ХХК-тай тухайн орд газарт улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлүүлэх ХАЗ-2004/01/37

дугаар гэрээ байгуулахдаа 31651 ам.доллар буюу 36841800 төгрөгийг дутуу тооцсон зөрчлийг илрүүлж, улсын төсөвт нөхөн төлүүлэх нь зүйтэй гэж үзэв.

1.30 Таван толгой ХК, Шивээ овоо ХК, Эрдэнэт үйлдвэр улсын төсвөөс хайгуулын ажилд гаргасан зардлыг нөхөн төлөх гэрээгүйгээр олборлолт явуулж байна.

Хайгуулын болон ашиглалтын ажил төлөвлөсөн хэмжээнд хийгдээгүй байна

1.31 Аудитад хамрагдсан стратегийн ач холбогдол бүхий орд газруудад 2006 онд 18 хуулийн этгээд нийт 196 301 га талбайд хайгуулын ажил хийхээр төлөвлөснөөс 8 хуулийн этгээд 76 171 га талбайд хайгуулын ажлыг гүйцэтгэсэн нь 38,8 хувь болж байна.



1.32 Харин аудитад хамрагдсан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 24 хуулийн этгээдийн хувьд нийт 171 087 га талбайд ашиглалтын үйл ажиллагаа явуулахаас 8 хуулийн этгээд 144 498 га талбайд ашиглалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

1.33 Үүнээс үзэхэд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүд хайгуулын болон ашиглалтын ажлыг төлөвлөсөн хэмжээнд хийгээгүй байна.

1.34 Салбар хариуцсан яам, агентлагийн тусгай зөвшөөрлийг бүртгэх, олгох, хугацааг сунгах, төлөвлөгөө, тайланг хүлээн авах, хянах үйл ажиллагаа хуулийн этгээдийн хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаатай уялдахгүй байна. Тухайлбал, Бүрэнхааны фосфоритын ордод хайгуулын тусгай зөвшөөрөлтэй Топроунхэнцо ХХК 2001 оны 9 дүгээр сараас өнөөг хүртэл ямар ч үйл ажиллагаа явуулаагүй, төлөвлөгөө хийж батлуулаагүй, тайлан ирүүлээгүй боловч энэ хугацаанд тусгай зөвшөөрлийг 2 удаа сунгуулж, шинэчилсэн бүртгэлд бүртгүүлжээ.

Мэдээ, тайланг хугацаанд нь бүрэн ирүүлээгүй байна

1.35 Ашигт малтмалын тухай (1997 оны) хуулийн 39 дүгээр зүйлийн 1-д “Лиценз эзэмшигч нь бүх мэдээ, тайланг хугацаанд нь үнэн зөв гаргаж, мэргэжлийн байгууллага болон ГУУКА-нд тус бүр нэг хувийг хүргүүлнэ” гэж заажээ. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн ордын нөөц, эрэл хайгуулын үр дүнгийн нэгдсэн тайланг батлагдсан маягт, бусад шаардлагад нийцүүлэн боловсруулж, анхдагч материалын хамт төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх журамтай.

1.36 Аудитад хамрагдсан стратегийн ач холбогдол бүхий орд газруудад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2006 онд ирүүлсэн тайлан, төлөвлөгөөг хүснэгтээр үзүүлбэл:

Үзүүлэлт	Хайгуулын лиценз эзэмшигчээс			Ашиглалтын лиценз эзэмшигчээс		
	Ирүүлбэл зохих	АМГТХЭГ-т ирүүлсэн	Ирүүлээгүй	Ирүүлбэл зохих	АМГТХЭГ-т ирүүлсэн	Ирүүлээгүй
Төлөвлөгөө	34	17	17	57	21	36
Тайлан	34	15	19	57	21	36

1.37 Дээрх хүснэгтээс үзэхэд стратегийн ач холбогдолтой орд газрын тусгай зөвшөөрөл эзэмшигчид тайлан, төлөвлөгөөг мэргэжлийн хяналтын болон төр

захиргааны байгууллагаар хянуулж, баталгаажуулан мөрдөх ажил хангалтгүй байна. (Хавсралт 2)

1.38 Иймд тусгай зөвшөөрөл олгох, хугацааг нь сунгахад тавих хяналтыг сайжруулж, төлөвлөгөө батлуулаагүй, мэдээ тайлан ирүүлэхгүй, үйл ажиллагаа явуулахгүй байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуулийн дагуу хариуцлага тооцох шаардлагатай байна.

1.39 АМХЭГ (хуучин нэрээр) болон ГУУХА-ны даргын 1997 оны 45/08 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлэх мэдээ, тайлангийн заавар, аргачлал”-д “борлуулалтын тайланд борлуулсан ба борлуулахаар ачуулсан газрын нэр, хаягийг тодорхой бичнэ” гэж заасан байхад зөвхөн борлуулсан бүтээгдэхүүний нэр, тоо хэмжээ, үнийг нийт дүнгээр нь тайлагнасан, эдийн засгийн үзүүлэлтийн тайланд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, байгаль хамгаалах зардал, НӨАТ, үндсэн хөрөнгийн элэгдэл зэрэг тоон мэдээллийг дурдаагүй, үйлдвэрээс гаргасан молибдений баяжмалын тоо хэмжээг буруу тайлагнасан зэрэг зөрчлүүд гарч байна. Тухайлбал, Эрдэнэт үйлдвэрээс гаргасан молибдений баяжмалын тоо хэмжээ санхүүгийн тайланд 3022,032 тн, нөөцийн тайлангийн техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд 2468,594 тн, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны мэдээлэлд 4581,03 тн гэх мэт өөр өөр тусгагджээ.

1.40 Хайгуулын болон ашиглалтын үр дүнгийн тайланг худлаа гаргах, шаардлага хангахгүй тайланг буцаах тохиолдол их гарч байгаа тул цаашид геологчдыг итгэмжлэх, эрдэс баялгийн шинжээчдийн мэргэжлийн ур чадварыг сайжруулах, мэргэжлийн байгууллагаас тавих хяналтыг өндөржүүлэх шаардлагатай байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нар байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэхгүй байна



1.41 Аудитад хамрагдсан 40 хуулийн этгээдийн 85.0% буюу 34 нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө хийж батлуулаагүй, байгаль орчны талаар хүлээх үүргийн урьдчилгаа төлбөрийг орон нутгийн төсөвт байршуулаагүй, 72.5 % буюу 29 нь байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажлын тайланг өгөөгүй байна. Тухайлбал, Таван толгой ХК, Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр, Энержи ресурс

ХХК, Монросцветмет нэгдэл байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө хийж батлуулаагүй байна.

1.42 БОЯ, АМГТХЭГ-аас ирүүлсэн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн "Ашигт малтмалын тухай" хуулийн байгаль орчныг хамгаалах талаархи заалтыг хэрэгжүүлж буй байдлын судалгаанаас үзэхэд ашиглалтын лиценз эзэмшигч 24 хуулийн этгээдийн 58.3 % буюу 14 нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгүүлээгүй байна.

1.43 Энержи ресурс ХХК, Эрдэнэт үйлдвэр, Багануурын уурхай ХК байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн боловч Ашигт малтмалын тухай хуулийн дагуу төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж батлуулаагүй, уг арга хэмжээнд зарцуулагдах хөрөнгийн урьдчилгаа төлбөрийг орон нутгийн төсөвт байршуулаагүй байжээ.

1.44 Хөвсгөл аймаг дахь фосфоритын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч Сутайхэнцо, Талстмаргад, Топруонхэнцо, Хөхтолбобут, Бумангазар зэрэг компаниуд байгаль хамгаалах төлөвлөгөө хийж батлуулаагүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгүүлээгүй байна.

1.45 Дээрх байдлаас үзэхэд стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын орд газрын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нар байгаль орчныг хамгаалах талаархи хуулийн заалтуудыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна. Иймд дээр дурдсан хуулийн этгээдэд хуульд заасны дагуу тодорхой хариуцлага тооцох, зөрчил давтагдвал тусгай зөвшөөрлийг нь цуцлах шаардлагатай байна.

Шалгалтаар ногдуулсан торгууль, төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна

1.46 2006 оны эцсийн байдлаар хяналтын байгууллагуудын шалгалтаар нийт 6901,3 сая төгрөгийн торгууль, төлбөр ногдуулснаас 75 хувь буюу 5182,2 сая төгрөгийг барагдуулжээ. Барагдуулаагүй торгууль, төлбөрийг хүснэгтээр үзүүлбэл:
(сая төгрөгөөр)

Хуулийн этгээдийн нэр	Шалгасан байгууллага	Төлбөр, зөрчлийн утга	Төлбөр, зөрчлийн хэмжээ	Төлөлт	Үлдэгдэл
“Чинхуа-МАК Нарийнсухайт” ХХК	УМХГ	Борлуулалтын үнийн зөрүүд нөөцийн төлбөр дутуу төлсөн	1731,3	552,0	1179,3
“Шивээ-Овоо” ХК	УМХГ	Санхүүгийн зөрчил	1,9	1,7	0,2
“Цайрт минерал” ХХК	ҮАГ	Ажлын байрны төлбөрийн дутуу	539,6		539,6
ДҮН			2272,8	553,7	1719,1

1.47 УМХГ-аас Чинхуа МАК Нарийнсухайт ХХК-д 2005 оны 9 дүгээр сард хийсэн шалгалтаар БНХАУ-д экспортолсон нүүрсний гэрээний үнийг ЭХСХТ-өөс гаргасан тухайн төрлийн нүүрсний олон улсын зах зээлийн үнийн мэдээтэй харьцуулан үнийн зөрүүгээр нөөц ашигласны төлбөрт 1731,3 сая төгрөгийг төлүүлэхээр акт тогтоосон байна. Компани энэ асуудлаар Засгийн газар, Сангийн яаманд хүсэлт тавьсны дагуу Сангийн сайдын 2006 оны 313 дугаар тушаалд Чинхуа МАК Нарийнсухайт ХХК-иас 2006 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл экспортлосон нүүрсэнд ногдох татварыг Тогтвортой байдлын гэрээ байгуулах үед тогтоосон үнийн түвшингээр тооцон төлж байсныг зүйтэй гэж үзсэнээс актын төлбөрийн үлдэгдэл 1179,3 сая төгрөгийг төлөөгүй байна.

1.48 Ажлын байрны нөхөн төлбөрөөс үндэслэлгүй чөлөөлсөн гэж ҮАГ-аас үзээд Цайрт минерал компаниар 539,6 сая төгрөгийг төлүүлэх акт тогтоосон боловч тус компани Засгийн газрын 2003 оны 254 дүгээр тогтоолоор ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдсөн гэдэг шалтгаанаар хэрэгжүүлээгүй байна. Гэтэл энэ тогтоол нь Засгийн газрын 2001 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын 11 дүгээр зүйлийг зөрчжээ.

1.49 Цайрт минерал ХХК 2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу гадаадын иргэний ажлын байрны төлбөрт 111280,8 мянган төгрөг, Чинхуа-МАК Нарийн сухайт ХХК 12700,0 мянган төгрөгийг төлөөгүй байсныг орон нутгийн төсөвт нөхөн төлүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Бүлэг 2

Тогтвортой байдлын гэрээ тооцоо муутай хийгджээ

Тогтвортой байдлын гэрээ байгуулахдаа эдийн засгийн тооцоо, дүн шинжилгээ сайтар хийж чадаагүй байна

2.1 Монгол Улсын Засгийн газраас Татварын ерөнхий хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн /1997 оны/ холбогдох заалтыг үндэслэн Бороо гоулд ХХК, Цайрт минерал ХХК, Чинхуа-МАК Нарийнсухайт ХХК-тай Тогтвортой байдлын гэрээг байгуулан ажиллаж байна. Үүнд:

Гэрээ байгуулсан			Гэрээний		Эх үүсвэр
Огноо	Засгийн газрын гишүүн	Компаний нэр	Ерөнхий хугацаа	Хөрөнгө оруулалтын хэмжээ /мян.\$/	
1998.05.13	Сангийн сайд Б.Батбаяр	Монгол Улсын Металлимпекс ХХК, Хятад Улсын Өнгөт төмөрлөгийн байгуулалтын компаний хамтарсан хөрөнгө оруулалттай Цайрт минерал ХХК	1998.05.13 2013.05.13	21000,0	Хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр олгосон зээл-200 сая юань
1998.07.06	Сангийн сайд Б.Батбаяр	Монгол-Их Британий хамтарсан хөрөнгө оруулалттай Бороо гоулд ХХК	1998.07.06 2008.07.06	15000,0	Хөрөнгө оруулагчийн эх үүсвэрээр
2000.05.09	Сангийн сайд Я.Очирсүх		2008.07.06 2013.07.06	10000,0	
2005.07.04	Сангийн сайд Н.Алтанхуяг	Монгол Улсын Монголын алт-МАК ХХК, Хятад Улсын Чинхуа компаний хамтарсан хөрөнгө оруулалттай Чинхуа-МАК Нарийн сухайт ХХК	2005.07.04 2015.07.04	5299,3	Хөрөнгө оруулагчийн эх үүсвэрээр
Хөрөнгө оруулалтын нийт дүн				51299,3	

2.2 Эдгээр гэрээнд татварын орчныг хөнгөлөх талаар тусгасан заалт гэрээний ерөнхий хугацааны заалттай зөрчилдөж байна. Тухайлбал, Цайрт минерал ХХК-тай байгуулсан гэрээний хугацаа 1998-2013 он байхад татварын хөнгөлөлтийн хугацаа үйлдвэрлэл ашиглалтад орсон 2005 оноос эхлэн 2020 оныг хамрахаар байна.

2.3 Тогтвортой байдлын гэрээ байгуулсан гурван удаагийн туршлагаас үзэхэд Засгийн газар эдийн засгийн тооцоо, дүн шинжилгээ сайтар хийж чадаагүй байна. Тухайлбал, Бороогоулд ХХК-ийн олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа Бороогийн алтны ордын тогтоогдсон нөөцийн үлдэгдэл одоогийн хүчин чадлаар 2 жил үйлдвэрлэл явуулахад буюу 2009 оны эхний хагаст дуусахаар байна.

2.4 МУЗГ-аас байгуулсан Тогтвортой байдлын гэрээний хөрөнгө оруулалтын үр ашгийг компани бүрээр харуулбал:

(сая төгрөгөөр)

Компаний нэр	Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл	Цэвэр ашиг			Хөрөнгө оруулагчид ногдох өгөөж /төг/
		2005	2006	Дүн	
Бороо гоулд ХХК	130307,5	94670,9	152018,0	246688,9	1,89
Цайрт минерал ХХК	55000,2	5630,0	83484,2	89114,2	1,62
Чинхуа-МАК Нарийн сухайт ХХК	3653,0	15477,1	21994,1	37471,2	10,25
Нийт дүн	188960,7	115778,0	257496,3	373274,3	

Хүснэгтээс үзэхэд Тогтвортой байдлын гэрээтэй 3 компани үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа нийт 188960,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 2005-2006 онд 373274,3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, оруулсан хөрөнгө оруулалтаа 1,62 -10,25 дахин нөхжээ.

2.5 БНХАУ-аас Монгол Улсад хөнгөлөлттэй зээл олгох тухай хоёр улсын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээрийг 1998, 2000 онд 2 удаа хийж баталгаажуулсан байна. Эхний хэлэлцээрээр БНХАУ-ын “Экспорт, импорт” банкнаас 100 сая юаний хөнгөлөлттэй зээлийг Монгол Улсын Засгийн газрын зөвшөөрсөн жинхэнэ хэрэглэгчид олгож, үйлдвэрлэлийн шинж чанартай төсөлд ашиглахаар МУ-ын Засгийн газрыг төлөөлж Р.Амаржаргал гарын үсэг зуржээ. Дараагийн хэлэлцээрт зээлийн хэмжээг 100 сая юаниар нэмэгдүүлэн хоёр талын хэлэлцэн тохиролцсон Монгол Улсын Төмөртийн овооны цайрын ордын төсөлд ашиглахыг зарчмын хувьд зөвшөөрч, МУ-ын Засгийн газрыг төлөөлөн Санхүү эдийн засгийн сайд Ч.Улаан гарын үсэг зуржээ.

2.6 СЭЗЯ-ны Эдийн засгийн хамтын ажиллагааны удирдлага зохицуулалтын газрын дарга Х.Амарсайханы гарын үсэгтэй 2001 оны 1 дүгээр сарын 9-ний 02a/77 дугаар албан бичгээр БНХАУ-ын Элчин сайдын яаманд “Хятад Улсаас Монгол Улсад олгох 100 сая юаний хөнгөлөлттэй зээлийн жинхэнэ хэрэглэгч нь Хятадын Өнгөт төмөрлөгийн байгуулалтын хувьцаат компани болохыг үүгээр мэдэгдэж байна” гэсэн зөвшөөрлийг хүргүүлсэн байна.

2.7 Хятадын Өнгөт төмөрлөгийн байгуулалтын ХК, Цайрт минерал ХХК-ний хооронд байгуулсан MG259001 дугаартай гэрээний дагуу үйлдвэрийг барьж ашиглалтад хүлээлгэж өгсөн өдрөөс эхлэн гэрээний үнийг хүүгийн хамт 7 жилийн хугацаанд Цайрт минерал ХХК төлж дуусгахаар заажээ.

2.8 Дээрх байдлаас үзэхэд Хятад Улсаас Монгол Улсад хөнгөлөлттэй зээл олгох тухай МУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээр гэж нэрлэж, мөн хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд “Энэхүү зээлтэй холбоотой зээлийн үндсэн өр, хүүгийн болон аливаа төлбөрийг Монгол Улсын Засгийн газар хариуцахгүй” гэж заасан нь Монгол Улсын Засгийн газар Төмөртийн овооны цайрын ордоор баталгаа гаргаж Хятадын Өнгөт төмөрлөгийн байгуулалтын ХК-д зээл олгуулсан гэж үзэхээр байна.

2.9 Үйлдвэрийн нийт үнэ 44880400 ам доллар бөгөөд үүний 55,1 хувь нь Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу авсан 200 сая юаний хөнгөлөлттэй зээл, үлдсэн 44,9 хувь нь Хятадын Өнгөт төмөрлөгийн байгуулалтын ХК “Экспорт, импорт” банкнаас авсан арилжааны зээлээр санхүүжигдэж, энэ нь Цайрт минерал ХХК-ийн санхүүгийн тайлан тэнцлийн эх үүсвэр талд өр төлбөрийн хэсэгт тайлагнагджээ.

2.10 Цайрт минерал ХХК зээлийг 2006 оны 3 дугаар сараас төлж эхэлсэн бөгөөд 2007 оны 4 дүгээр сарын 1-ний байдлаар зээл, зээлийн хүүгийн төлбөрийн 79,7 хувь буюу 36650721,04 ам.долларыг төлж, одоо 9341487,8 ам. долларын үндсэн зээл, 1138896,26 ам.долларын хүүгийн өглөгтэй байна.

2.11 2006 онд баталсан Ашигт малтмалын тухай хуульд хөрөнгө оруулагч нь төрийн захиргааны байгууллагад ирүүлэх гэрээ байгуулах хүсэлт, гэрээний төслийн баримт бичигт тухайн ордын нөөцийг улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг заавал хавсаргахаар заасан. Гэтэл Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс Оюу толгойн ордын хайгуулын ажлын тайланг авч хэлэлцэн нөөцийг улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн шийдвэр өнөөгийн байдлаар гараагүй байхад МУЗГ-аас томилогдсон ажлын хэсэг Оюу толгой төслийг хэрэгжүүлэгчтэй Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах яриа хэлцэл хийж байна.

Тогтвортой байдлын гэрээнээс хамаарч аж ахуйн нэгжүүдийн татвар төлөлт жигд бус байна

2.12 2006 онд 8 орд газарт олборлолт хийж буй компаниудын нөөц ашиглалтын төлбөр төлөлтийг хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

д/д	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн				Ашигт малтмал борлуулалтын		Ногдуулалт		
	Дугаар	Эзэмшигч хуулийн этгээдийн нэр	Талбайн хэмжээ /га/	Олгосон огноо	Тоо хэмжээ /мян.тн/	Үнийн дүн	Нийт ногдуулалт	Тогтвортой байдлын гэрээгээр хөнгөлөлт	Төлөх нь
1	011А	"Эрдэнэт" УҮГ	2552	1996.04.06		817259.8	27140.8		27140.8
2	287А;11945А	"Тавантолгойн уурхай" ХК	169	1995.09.08	787.3	29631.0	1141.7		1141.7
3	227А-6ш	"Чинхуа-МАК Нарийн сухайт" ХХК	1229	1995.10.08	1548.6	31777.5	1035.4	241.0	794.4
4	901А	"Шивээ-Овоо" ХК	91	1995.10.08	1306.8	9825.9	245.6		245.6
5	1371А	"Багануур" ХК	1445	1998.10.09	2760.9	31934.1	798.4		798.4
6	939А	"Төмөртэйн хүдэр" ХХК	1200	1998 он	179.7	7623.7	190.6		190.6
7	198А:15ш	"Бороогоулд" ХХК	6525.1	1997.06.21	Алт 8756.2 Мөнгө 1244.6	201313.1	6867.0	1834.15	5032.9
8	723А	"Цайртминерал" ХХК	38	1997.08.13	197.2	105508.7	3715.5	1077.75	2637.8
		ДҮН				1234873.8	41135.0	3152.9	37982.1

2.13 Эрдэнэт үйлдвэр, Тавантолгойн уурхай ХК-ний 2006 оны 9 дүгээр сарын 1-нээс хойшхи хугацаанд хийсэн борлуулалтад нөөц ашиглалтын төлбөрийг шинэчилсэн хуулийн дагуу 5 хувиар ногдуулжээ. (Хавсралт №3-аас үзнэ үү)

2.14 Тогтвортой байдлын гэрээнд нөөц ашиглалтын төлбөрийг тогтмол 2,5 хувь байхаар заасны улмаас гэрээтэй 3 компаниас зөвхөн 2006 оны сүүлийн 4 сарын байдлаар 3152,9 сая төгрөгийн нөөц ашиглалтын төлбөрийг төсөвт төвлөрүүлэх боломжийг алджээ. Цаашид байгалийн нөөц ашигласны төлбөрийг мөрдөгдөж байгаа хуулийн дагуу төлж байхаар гэрээнд тусгах нь зүйтэй байна.

2.15 Аудитаар хуулийн этгээдүүдийн санхүүгийн үйл ажиллагааг бүхэлд нь шалгах боломжгүй байсан тул орлогын албан татвар төлөлтийн тооцоог татварын албанаас хянасан тайлан, УТЕГ-аас авсан судалгаанд үндэслэн хийлээ.

Хуулийн этгээдүүдийн 2006 оны үр дүн, орлогын албан татварын ногдуулалт, төлөлтийн байдлыг харуулбал:

(сая төгрөгөөр)

Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр	Нийт борлуулалт	Зардал /Татварын тайлангаар/	Татвар ногдох орлого	Ногдуулах татвар	Тогтвортой байдлын гэрээгээр чөлөөлөлт	Компаний мэдэлд үлдэх цэвэр ашиг	Төлөлт	Эхний үлдэгдэл	Тайлант оны зөрүү
"Эрдэнэт" УУГ	840842,3	445404,5	395437.8	118616.3		276821.5	127651	-18419	-9384.8
"Таван толгойн уурхай" ХХК	8233.9	1261.3	6972.6	2076.8		4895.8	1518.3	-38.3	-596.8
"Чинхуа-МАК Нарийн сухайт" ХХК	31777.5	9783.4	21994.1	6583.2	6583.2	21994.1	0.0		
"Шивээ-Овоо" ХК	9825.9	11045.5	-1219.6						
"Багануур" ХК	32340.7	31440.6	900.1	255.0		645.1	269.8	-269.8	-255.0
"БЛТ"- "Төмөртэйн хүдэр" ХХК	7623.7	7458.5	165.2	34.6		130.6	28.1	0.0	-6.5
"Бороогоулд" ХХК	201313,1	49295,1	152018.0	45590.4	45590.4	152018.0	0.0		
"Цайрт минерал" ХХК	105508.7	22024.5	83484.2	25030.3	25030.3	83484.2	0.0		
ДҮН	1237465,8	577713,4	659752.4	198186.6	77203.9	539989.3	129467.1	-18727.1	-10242.7

2.16 Тайлант онд дэлхийн зах зээл дээр металлын үнэ тогтвортой өсөж байсан нь уул уурхайн үйлдвэрлэл эрхэлж байгаа компаниудад тааламжтай нөхцөлийг бий болгосон. Тухайлбал, үнэт болон холимог металлын олборлох үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал Эрдэнэт үйлдвэрт 0.53, Бороо гоулд ХХК-д 0.25, Цайрт минерал ХХК-д 0.21 төгрөг байна. Харин Төмөртэйн хүдэр ХХК 1 төгрөгийн борлуулалтад 0,98 төгрөг зарцуулж байгаа нь бодит байдлаас зөрүүтэй байна.

2.17 Олборлолт хийж байгаа 8 хуулийн этгээдээс 2006 онд Шивээ овоо ХК-аас бусад нь 130.6-276821.5 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч Тогтвортой байдлын гэрээ байгуулсан Бороо гоулд ХХК 45,6 тэрбум, Цайрт минерал ХХК 25,0 тэрбум, Чинхуа-МАК Нарийнсухайт ХХК 6,6 тэрбум төгрөгийн орлогын албан татвар төлөхөөс бүрэн чөлөөлөгджээ.

2.18 Нэг аймгийн нутагт олборлолт хийж байгаа "Тавантолгой" ОНӨХК, Монгол Хятадын хамтарсан хөрөнгө оруулалттай хувийн "Чинхуа-МАК Нарийнсухайт" ХХК-ний орлогын албан татвар, ашигт малтмалын нөөцийн төлбөр төлөлтийг харьцуулбал:

Хуулийн этгээдийн нэр	Ажиллагсдын тоо	Борлуулалт			Нийт зардал	Татвар ногдох орлого	Татвар төлөлт				Татварын дараах цэвэр ашиг	Орон нутгийн төсөвт төлөх ногдол ашиг	Бусад хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг	Компаний мэдэлд үлдэх цэвэр ашиг
		Тоо хэмжээ /мян.тн/	Үнийн дүн /мян ₮/	Тухайн компанид ногдох			Орлогын албан татвар	Ашигт малтмалын нөөцийн төлбөр	Үүнээс компаний зардалд тооцох	НӨАТ				
"Тавантолгойн уурхай" ХК	253	787.3	29631.0	8233.9	1261.2	6972.7	2076.8	1141.7	342.9	725.8	4895.8	1747.8	1679.3	1468.7
"Чинхуа-МАК Нарийнсухайт" ХХК	124	1548.6	31777.5	31777.5	9783.4	21994.1		794.4			21994.1		х	х

2.19 Дээрх хүснэгтээс харахад 2006 онд “Чинхуа МАК Нарийнсухайт” ХХК нь “Таван толгойн уурхай” ОНӨХК-иас 2 дахин их хэмжээний нүүрс (газрын баялаг) олборлож экспортлосон боловч 6,2 дахин бага татвар төлж, 4,5 дахин их ашиг олжээ.

2.20 Таван толгойн уурхай ХК нь Тавантолгой Транс ХХК, Хятад улсын Пү-шин ХХК-тай өөрийн эзэмшлийн тусгай зөвшөөрөлтэй талбайгаас нүүрс олборлуулж, БНХАУ-д борлуулах гэрээ байгуулан ТУЗ-ийн дарга Н.Наранбаатараар батлуулжээ. Гэрээгээр тн тутамд 8,6 ам долларыг Тавантолгойн уурхай ХК-д төлөхөөр заасан бөгөөд 2006 онд ногдох нөөцийн төлбөрт нийт 342,9 сая төгрөг төлсөн байна. Гэрээт борлуулагч 2 компани уг нүүрсийг тн тутамд 26 ам доллар нэмэн 34,6 ам доллараар Хятадын зах зээлд борлуулж, зөрүү 26 ам.долларт ногдох нөөцийн төлбөрийг төлдөг.

2.21 Эдгээр компаниудтай нүүрс худалдах, худалдан борлуулах тухай гэрээ байгуулсан гэх боловч гэрээний 1.2, 1.3 дугаар заалтаас үзэхэд борлуулалтын бус ашигт малтмал олборлуулах гэрээ болжээ. Мөн гэрээний үүргийн хяналтын талаар дурдаагүй байна. Тавантолгойн уурхай ХК орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд учраас дээрх гэрээг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуульд нийцүүлэн орон нутгийн ИТХ-аар хянуулж, шинэчлэх нь зүйтэй байна.

2.22 ҮХЯ-наас ирүүлсэн танилцуулга, ажлын баримтуудад үндэслэн стратегийн ач холбогдол бүхий нүүрсний орд газруудыг харьцуулбал:

д/д	Ордын нэр	Илчлэг /ккал/кг/	1 тн нүүрсний борлуулалтын үнэ	
			Экспорт	Дотоод
1.	Таван толгойн ордын чулуун нүүрс	7760-8120	34,6\$	12000₮
2.	Нарийнсухайтын ордын чулуун нүүрс	6435-6935	15-21\$	
3.	Багануурын ордын хүрэн нүүрс	3380-3421		11500₮
4.	Шивээ-овоогийн ордын хүрэн нүүрс	3024 ккал		7500₮

2.23 Үүнээс үзэхэд Нарийнсухайтын ордын нүүрсний илчлэг Таван толгойн нүүрсний илчлэгээс 15,8 хувиар бага байхад экспортод гаргаж буй үнэ 2 дахин бага, Багануурын ордын хүрэн нүүрсний илчлэгээс 2 дахин илүү боловч экспортолж буй үнэ дотоодод борлуулж байгаа үнээс төдийлөн өндөр бус байна.

2.24 2006 оны 9 дүгээр сар хүртэл үйл ажиллагаа явуулсан Төмөртэйн хүдэр ХХК-иас бусад компаниуд НӨАТ төлөгчөөр бүртгүүлж, тайлант онд 3 хуулийн этгээд 3419,2 сая төгрөгийг НӨАТ-т төлжээ.

НӨАТ төлөлт болон түүний буцаалтын тооцоог дараахь хүснэгтээр харуулав.

(сая.төгрөгөөр)

Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр	Борлуулалт	Тэг хувьтай борлуулалт	НӨАТ ногдох борлуулалт	Ногдуулсан НӨАТ	НӨАТ-тай худалдан авалтаар хасагдах	Төлбөл зохих НӨАТ	Төлсөн НӨАТ	Буцаан олголтоор тооцуулсан	Эхний үлдэгдэл	Тайлант оны ээрүү
"Эрдэнэт" УУГ	840842.3	825612.9	15229.4	2284.4	29810.2	- 27525.8		30326.7	- 4949.1	-2148.2
"Тавантолгойн уурхай" ХК	8233.9	3186.3	5047.6	757.1	31.3	725.8	669.0		-2.3	54.5
"Чинхуа-МАК Нарийн сухайт" ХХК	31777.5	31774,0	3.5	0.5	113.2	-112.7				-112.7
"Шивээ-Овоо" ХК	9825.9		9825.9	1473.9	737.2	736.7	691.1			45.6
"Багануур" ХК	32340,7		32340,7	4851,1	3172.0	1679.1	2059.1		177.5	-202.5
"Бороогоулд" ХХК	201313.1	201313.1	0.0	0.0	1449.8	-1449.8		1449.8		0.0
"Цайртминерал" ХХК	105508.7	105508.7	0.0	0.0	1400.0	-1400.0				-1400.0
"Айвенхоу майнз Монголиа инк" ХХК	2683.6		2683.6	402.5	13049.2	-12646.7		7724.9	- 3629.9	-8551.7
ДҮН	1232525,7	1167395,	65130,7	9769,5	49762,9	-39993.4	3419.2	39501.4	- 8403,8	-12315,0

2.25 Багануур ХК, Шивээ овоо ХК-иас бусад хуулийн этгээд НӨАТ-ын тухай хуулийн 6.3-т "Экспортод гаргасан бараа, ажил үйлчилгээнд ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тэг ("0")-тэй тэнцүү байна" гэж заасны дагуу НӨАТ-аас чөлөөлөгдсөнөөр төсвөөс буцаан авах тооцоо ихээр үүсч байна. Тухайлбал, Бороо гоулд ХХК 2005 онд 152823,5 сая төгрөгийн борлуулалт хийж, 3820,6 сая төгрөгийн нөөцийн төлбөр төлөх ёстойгоос НӨАТ-ын буцаан олголтоор 3508,4 сая төгрөгийг суутгуулан тооцож, төсөвт 312,2 сая төгрөгийн нөөцийн төлбөр төлжээ.

2.26 Оюутолгойн орд газарт хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа Айвенхоу майнз Монголиа инк ХХК тайлант онд олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй боловч гэрээгээр хайгуулын ажил үйлчилгээ гүйцэтгэсэн болон түрээсийн орлогоор нийт 2683,6 сая төгрөгийн орлого олсноос 402,5 сая төгрөгийн НӨАТ төлөхөөр тооцсон байна. Тухайн онд тус компани 13049,2 сая төгрөгийн НӨАТ-тай бараа, ажил үйлчилгээ худалдан авснаар 7724,9 сая төгрөгийг бусад татвар хураамжаас суутгуулж, оны эцсийн тооцоогоор 8551,7 сая төгрөгийн НӨАТ-ын авлагатай байна.

2.27 2006 оны турш дэлхийн зах зээл дээр алт, зэс болон бусад металлын үнэ байнга өсөж байсан учир тухайн онд УИХ-аас баталсан Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн дагуу Эрдэнэт үйлдвэр 172,6 тэрбум төгрөгийг улсын төсөвт төлжээ. ҮТЕГ-аас Бороо гоулд ХХК-ийг МУЗГ-тай Тогтвортой байдлын гэрээ байгуулсан гэдэг үндэслэлээр тухайн төрлийн татварын ногдуулалтыг тооцолгүй орхисноос хэдэн төгрөг татвараас чөлөөлөгдөж байгаа нь тодорхойгүй байна. Татварын байгууллага аж ахуйн нэгжүүдтэй татвар, хураамжийн төрөл бүрээр татварын ногдуулалт, чөлөөлөлтийн тооцоог хийж, тайланг баталгаажуулж байх үүрэгтэй билээ.

2.28 Стратегийн ач холбогдол бүхий орд газарт олборлолт хийж байгаа компаниудын 2006 онд улсын төсөвт төлсөн 327,3 тэрбум төгрөгийн (4 төрлийн) татварын 312,8 тэрбум төгрөг буюу 95,6 хувийг дан ганц Эрдэнэт үйлдвэр төлжээ.



2.29 МУЗГ-тай Тогтвортой байдлын гэрээ байгуулсан хуулийн этгээдүүд ижил төрлийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хуулийн этгээдээс татварын хэт их хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлж байгаа нь тухайн ордын стратегийн ач холбогдол, улс орны эдийн засагт оруулах хувь нэмрийг бууруулж, чөлөөт өрсөлдөөнийг үгүйсгэж, тэгш байдлыг бий болгож байна.

2.30 Олон улсын хэмжээнд газрын тос, байгалийн хий, уул уурхайгаас орох орлогоос хараат эдийн засагтай улс орнуудад ил тод, хариуцлагатай байдлыг хөхиүлэн дэмжсэнээр орлогыг буруу зохицуулснаас үүдэж болох сөрөг нөлөөллийг багасгаж, нөөц баялгаас орох орлогын засаглалыг сайжруулах, тухайн салбарыг тойрсон аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгоор ОСИТБС-ыг хэрэгжүүлж байна.

2.31 Монгол Улс ОСИТБС-д нэгдэж, оролцогч 3 тал болох Засгийн газар, компаниуд, төрийн бус байгууллагын эвслийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийг боловсруулсан байна. Уг санамж бичигт компаниудыг төлөөлж Эрдэнэт үйлдвэр, МАК ХХК, Айвенхоу майнз ХХК, Бороо гоулд ХХК-ний удирдлагууд гарын үсэг зуржээ.

2.32 Энэхүү хөтөлбөрт уул уурхайн компаниудыг бүрэн хамруулах, тэдгээрээс төлж байгаа бүх төлбөр, Засгийн газрын хүлээн авсан орлогын нэгтгэсэн тайланг компани болон орлого, төлбөрийн нэр төрлөөр нь задлан гаргаж, хөндлөнгийн хяналт хийлгэн хэвлэн нийтлэх, ОСИТБС-ын тасралтгүй, урт хугацааны тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авах нь зүйтэй байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболдод:

- Монгол Улсын Засгийн газраас стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрлийг эзэмшигч хуулийн этгээдтэй байгуулсан Тогтвортой байдлын гэрээг эргэн хянах, татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээ, үйлчлэх хугацааг хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр ашгийн түвшинтэй уялдуулан тогтоох асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх
- Уул уурхайн компаниудаас улс, орон нутгийн төсөвт төлж байгаа бүх төлбөр болон холбогдох бусад мэдээллийг ОСИТБС-ын шаардлагын дагуу ил тод болгох арга хэмжээ авах

Үйлдвэр, худалдааны сайд Ц.Даваадоржид:

- Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын хил хүрээг геологи-уул уурхайн кадастрын зурагт тусгаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах
- Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордод 18 хуулийн этгээдэд хайгуулын 34 тусгай зөвшөөрөл олгосныг хүчингүй болгох
- Хууль зөрчиж Энержиресурс ХХК, Дайцүки ХХК-д олгосон ашиглалтын тусгай зөвшөөрлийг хянан үзэж, зохих журмын дагуу шийдвэрлэх
- Улсын төсвөөс хайгуулын ажилд гаргасан зардлыг нөхөн төлөх гэрээг холбогдох компаниудтай байгуулж, төлүүлэх
- Төмөртийн овооны цайрын ордын хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийг Засгийн Газрын 1997 оны 234 дүгээр тогтоолын дагуу тогтоож, Цайрт минерал компанитай нөхөн төлбөрийн гэрээг шинэчлэн байгуулах
- Тусгай зөвшөөрөл олгох, хугацааг нь сунгахад тавих хяналтыг сайжруулж, төлөвлөгөө, тайлан ирүүлэхгүй, үйл ажиллагаа явуулахгүй байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хуулийн дагуу хариуцлага тооцох

Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд У.Хүрэлсүх нарт:

- Ашигт малтмалын болон Байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийг зөрчиж, хүлээсэн үүргээ биелүүлээгүй ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт холбогдох арга хэмжээг зохих журмын дагуу хүлээлгэх

Аудитад хамрагдсан стратегийн ач холбогдол бүхий орд газрын
ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны талаархи судалгаа

Ордын дугаар	Эзэмшигчийн дугаар	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн				Уулын ажлын төлөвлөгөөний биелэлт	Уулын ажлын төлөвлөгөөг батлуулсан эсэх	Ажлын тайланг ТЗБ-д ирүүлсэн эсэх	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж батлуулсан эсэх	Байгаль хамгаалах төлөвлөгөөг батлуулсан эсэх	Байгаль хамгаалах ажлын тайланг ТЗБ-д ирүүлсэн эсэх	БОХ үүргийн баталгаа зардлын 50 хувийг урьдчилан төлсөн эсэх
		Дугаар	Хуулийн этгээдийн нэр	Талбайн хэмжээ (га)	Олгосон огноо							
1	Дорноговь аймаг. Цагаан суваргын зэс молибдений орд											
	1	9630A	"Монголын алт" МАК	132	2005.04.18	Хайгуул хийж дуусаагүй, олборлолт явуулаагүй	батлуулсан	ирүүлсэн	батлуулаагүй	батлуулсан	ирүүлээгүй	байршуулсан
2	Орхон аймаг.Эрдэнэтийн зэс молибдений орд											
	2	011A	"Эрдэнэт" УУГ	2552	1996.04.06	Хүдрийн ил уурхай 18200мян.м3 уулын цул олборлохоос 18550 мян.м3 олборлож, 350 мян.м3-ээр, хөрс хуулалтын ажлыг 7808 мян.м3 төлөвлөж 7926.48 мян.м3 гүйцэтгэж 118.48 мян.м3-ээр тус тус давуулсан байна. Мөн 26500.0 мян.тн таваарын хүдэр олборлохоос 162698.7 тн зэс, 5003.77 тн молибден бүхий 27090.0 мян.тн олборлож, Баяжуулах фабрикт 25570.0 мян.тн, "Эрдмин" ХХК-д 602.0 мян.тн, хүдрийн склад /овоолго/-д 918.0 мян.тн хүдрийг тус тус ачуулжээ.	батлуулсан	ирүүлсэн	батлуулсан	балуулаагүй	ирүүлсэн	байршуулаагүй
	3	1701A	"Отгонтэнгэр оргил" ХХК	54	1999.06.22	Олборлолтын ажил явуулаагүй	батлуулаагүй	ирүүлээгүй	батлуулаагүй	батлуулаагүй	ирүүлээгүй	байршуулаагүй
3	Өмнөговь аймаг.Оюутолгойн зэсийн орд											
	4	6708	"Айвенхоу майнз Монголиа инк" ХХК	23867	2003.12.26	Хайгуул хийж дуусаагүй, олборлолт явуулаагүй, нөөц батлагдаагүй	нөөц батлагдаагүй	нөөц батлагдаагүй	батлуулсан	батлуулсан	ирүүлсэн	байршуулсан
4	Өмнөговь аймаг.Таван толгойн нүүрсний орд											
	5	287A; 11945A	"Таван толгойн уурхай" ХК	169	1995.09.08	Хөрс хуулалтын ажлыг 2465 мян.м3 төлөвлөснөөс 1751.7 мян.м3 гүйцэтгэж, 713.3 мян.м3-ээр, 1000.0 мян.тн нүүрс олборлохоос 787.1 мян.тн нүүрс олборлон борлуулж, 212.9 мян.тн-оор төлөвлөгөөг тасалдуулжээ	батлуулсан	ирүүлсэн	батлуулсан	батлуулаагүй	ирүүлээгүй	байршуулсан
	6	11952A-6ш	"Энержиресурс" ХХК	71482	2006.08.28	Олборлолтын ажил эхлээгүй	батлуулаагүй	ирүүлээгүй	батлуулсан	батлуулаагүй	ирүүлээгүй	байршуулаагүй
	7	11977A	"Дайцүки" ХХК	101	2006.08.28	Олборлолтын ажил эхлээгүй	батлуулаагүй	хугацаа болоогүй	батлуулаагүй	батлуулаагүй	ирүүлээгүй	байршуулаагүй
	8	11926A	"Брод" ХХК	70333	2006.08.21	Олборлолтын ажил эхлээгүй	батлуулаагүй	ирүүлээгүй				
5	Өмнөговь аймаг. Нарийнсухайтын нүүрсний орд											
	9	227A-6ш	"Чинхуа-МАК Нарийнсухайт" ХХК	1229	1995.10.08	3302.85мян.м3 хөрс хуулалт, 2025.0 мян.тн олборлолт хийхээр төлөвлөснөөс 1554.9 мян.тн нүүрс олборлож төлөвлөгөөг 470.1 мян.тн-оор тасалдуулсан байна.	5458A, 6852A, 12225A, 12226A батлуулсан	5458A, 6852A, 12225A, 12226A батлуулсан	батлуулсан	батлуулсан	ирүүлээгүй	байршуулсан
6	Говьсүмбэр аймаг.Шивээ-Овоогийн нүүрсний орд											
	10	901A	"Шивээ-Овоо" ХК	91	1995.10.08	1300.0мян.тн нүүрс олборлохоос 1306.5 мян.тн нүүрс олборлож төлөвлөгөөг 100.5 хувиар биелүүлсэн.	батлуулсан	ирүүлсэн	батлуулсан	батлуулсан	ирүүлсэн	байршуулаагүй
7	Багануурын нүүрсний орд											

	11	1371A	"Багануур" ХК	1445	1998.10.09	Хөрс хуулалтын ажлыг 11005.0 мян.м3 төлөвлөснөөс 11381.4 мян.м3 гүйцэтгэж, 376.0 мян.м3-ээр, нүүрс олборлолтыг 2800.0 мян.тн-ыг төлөвлөснөөс 2804.4 мян.тн олборлолт хийж 4.4 мян.тн-оор тус тус давуулан, 2760.9 мян.тн-ыг борлуулсан	батлуулсан	ирүүлсэн	батлуулаагүй	батлуулсан	ирүүлсэн	байршуулаагүй
8 Дорнод аймаг. Мардайн ураны орд												
9 Дорнод аймаг. Ураны орд												
	12	237A	"Төв азийн уран" ХХК	261	1997.12.06	Олборлолт хийгээгүй	батлуулаагүй	ирүүлээгүй	батлуулсан	батлуулсан	ирүүлээгүй	байршуулаагүй
10 Дорнод аймаг. Гурванбулагийн ураны орд												
	13	11899A	"Шинь-шинь" ХХК	301	2006.08.17	Олборлолт хийгээгүй	баталсан	ирүүлсэн	батлуулаагүй	батлуулаагүй	ирүүлээгүй	байршуулаагүй
11 Хөвсгөл аймаг. Бүрэнхааны фосфоритын орд												
	14	3996A	"Сутайхэнцэ" ХХК	34	2001.12.25	Олборлолт хийгээгүй	батлуулаагүй	ирүүлээгүй	батлуулаагүй	батлуулаагүй	ирүүлээгүй	байршуулаагүй
	15	3999A; 11428A	"Талстмаргад" ХХК	686	2001.12.26	Олборлолт хийгээгүй	батлуулаагүй	ирүүлээгүй	батлуулаагүй	батлуулаагүй	ирүүлээгүй	байршуулаагүй
	16	11823- 11824A	"Топроунхэнцэ" ХХК	78	2001.05.03	Олборлолт хийгээгүй	батлуулаагүй	ирүүлээгүй	батлуулаагүй	батлуулаагүй	ирүүлээгүй	байршуулаагүй
12 Сэлэнгэ аймаг. Төмөртэйн төмрийн хүдрийн орд												
	17	10811A	"И ян куан ие" ХХК	550	2005.11.14	Олборлолт хийгээгүй	батлуулаагүй	ирүүлээгүй	батлуулаагүй	батлуулаагүй	ирүүлээгүй	байршуулаагүй
	18	11426A- 2	"Легендмайнз" ХХК	362	2006.02.23	Олборлолт хийгээгүй	батлуулаагүй	ирүүлээгүй	батлуулаагүй	батлуулаагүй	ирүүлээгүй	байршуулаагүй
	19	939A	"БЛТ" ХХК-"Төмөртэй хүдэр" ХХК-д 2005	1200	1998 он	Хөрс хуулалтын ажлыг 340.0 мян.м3 төлөвлөснөөс 167.2 мян.м3 гүйцэтгэж 49.2 %, 800.0 мян.тн хүдэр олборлох төлөвлөгөөтэйгээс 461.1 мян.тн-ыг олборлон боловсруулж, 322.78 мянган тн бүтээгдхүүн үйлдвэрлэн борлуулжээ	батлуулсан	ирүүлсэн	батлуулсан	батлуулсан	ирүүлсэн	байршуулсан
13 Сэлэнгэ аймаг. Бороогийн алтны орд												
	20	198A: 16ш	"Бороогоулд" ХХК	6525.1	1997.06.21	Хөрс хуулалтыг 15322.0 мян.м3 төлөвлөснөөс 16864.0 мян.м3 хөрс хуулалт хийж, 2473.0 мян.тн хүдэр боловсруулан 7825.8 кг бүтээгдхүүн гаргах төлөвлөгөөтэй ажиллаж, 2314.0 мян.тн хүдэр боловсруулж, 8756.2 кг алт, 1244.6 кг мөнгө үйлдвэрлэн борлуулсан	батлуулсан	ирүүлсэн	батлуулсан	батлуулсан	ирүүлсэн	байршуулсан
	21	722A, 5147A	"Анод" банк	341	1997.08.08	Олборлолт хийгээгүй	батлуулаагүй	ирүүлээгүй	батлуулаагүй	батлуулаагүй	ирүүлээгүй	байршуулаагүй
	22	1817A, 6428A	"Сонортрейд" ХХК	172	1999.08.20	Цагаан чулуутад олборлолт хийгдэж байгаа	батлуулсан	ирүүлсэн	батлуулаагүй	батлуулаагүй	ирүүлээгүй	байршуулаагүй
14 Сүхбаатар аймаг. Төмөртэйн овооны цайрын орд												
	23	723A	"Цайртминерал" ХХК	38	1997.08.13	1.1 сая.м3 хөрс хуулж, 372.0 мян.тн хүдэр боловсруулж, 96.0 мян.тн хуурай баяжмал үйлдвэрлэжээ.	батлуулсан	ирүүлсэн	батлуулсан	батлуулсан	ирүүлсэн	байршуулсан
15 Баян-өлгий аймаг. Асгатын мөнгөний орд												
	24	4388A- 3ш	"Монголросцветмет" нэгдэл	1048	2002.05.09	Олборлолт хийгээгүй	батлуулаагүй	ирүүлээгүй	батлуулаагүй	батлуулаагүй	ирүүлээгүй	байршуулаагүй

Аудитад хамрагдсан стратегийн ач холбогдол бүхий орд газрын
хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны талаархи судалгаа

Ордын дугаар	Эзэмшигчийн дугаар	Хайгуулын тусгай зөвшөөрлийн				Хайгуулын ажлын төлөвлөгөөг батлуулсан эсэх	Ажлын тайлан, бусад материалыг ТЗБ-д ирүүлсэн эсэх	Шинэчилсэн бүртгэлд хамрагдсан эсэх
		Дугаар	Хуулийн этгээдийн нэр	Талбайн хэмжээ /га/	Олгосон огноо			
1 Дорноговь аймаг. Цагаан суваргын зэс молибдений орд								
	1	9626 X 9264 X	"Хөх тэнгэр тур" ХХК	19604	2005.02.04	батлуулсан	ирүүлсэн	Шинэчлэн бүртгүүлсэн
2 Говьсүмбэр аймаг. Шивээ-Овоогийн нүүрсний орд								
	2	8294 X -5 ш	"Шинэ-шивээ" ХХК	82039	2004.09.03	батлуулаагүй	ирүүлээгүй	Шинэчлэн бүртгүүлсэн
	3	9803 X	"Армагтрейд" ХХК	5340	2005.05.16	батлуулаагүй	ирүүлээгүй	Шинэчлэн бүртгүүлсэн
	4	11627 X	"Дуулгахалиут" ХХК	1646	2006.04.03	батлуулаагүй	ирүүлээгүй	Шинэчлэн бүртгүүлсэн
3 Улаанбаатар хот. Багануурын нүүрсний орд								
	5	12119 X	"Илчит-Эрдэс" ХХК	3080	2006.10.18	батлуулаагүй	ирүүлээгүй	Шинэчлэн бүртгүүлсэн
	6	12164 X	"Алтайголд" ХХК	12164	2006.11.06	батлуулаагүй	ирүүлээгүй	Шинэчлэн бүртгүүлсэн
4 Дорнод аймаг. Мардайн ураны орд								
	7	9283 X	"Эмээлт майнз" ХХК	127	2005.02.11	батлуулсан	ирүүлсэн	Шинэчлэн бүртгүүлсэн
5 Дорнод аймаг. Дорнодын ураны орд								
	8	9282 X	"Ханресорсез" ХХК	243	2005.02.11	батлуулсан	ирүүлсэн	Шинэчлэн бүртгүүлсэн
	9	4974 X	"Эмээлт майнз" ХХК	14167	2002.10.08	батлуулсан	ирүүлсэн	Шинэчлэн бүртгүүлсэн
6 Дорнод аймаг. Гурванбулагийн ураны орд								
	10	4969X	"Эмээлт майнз" ХХК	6751	2002.10.08	батлуулсан	ирүүлээгүй	Шинэчлэн бүртгүүлсэн
	11	4846 X	"Эмээлт майнз" ХХК	5753	2002.09.05	батлуулсан	ирүүлсэн	Шинэчлэн бүртгүүлсэн
	12	7685 X	"Вестерн проспектор" ХХК	7254	2004.06.10	батлуулсан	ирүүлсэн	Шинэчлэн бүртгүүлсэн
7 Хөвсгөл аймаг. Бүрэнхааны фосфоритын орд								
	13	9370 X 9371 X	"Бумангазар" ХХК	3828	2005.03.07	батлуулаагүй	ирүүлээгүй	Шинэчлэн бүртгүүлсэн
	14	11825 X 11826 X	"Топруонхэнцо" ХХК	1722	2001.09.24	батлуулаагүй	ирүүлээгүй	Шинэчлэн бүртгүүлсэн
	15	9888 X 9715 X 9718 X 11217 X	"Тефисмайнинг" ХХК	10014	2005.05.03	батлуулсан	ирүүлсэн	Шинэчлэн бүртгүүлсэн
	16	8911 X	"Юү Жи Эл Интерпрайзис"	2028	2004.12.9	батлуулсан	ирүүлсэн	Шинэчлэн бүртгүүлсэн
	17	6338 X	"Монголхэнцо" ХХК	111	2003.9.19	батлуулаагүй	ирүүлээгүй	Шинэчлэн бүртгүүлсэн
8 Сэлэнгэ аймаг. Бороогийн алтны орд								
	18	3405 X	"Бороогоулд" ХХК	4712	2001.6.19	батлуулаагүй	ирүүлсэн	Шинэчлэн бүртгүүлсэн
	19	5311 X 7703 X 7428 X	"Сентеррагоулд Монголия" ХХК	12269	2004.6.10	батлуулаагүй	ирүүлсэн	Шинэчлэн бүртгүүлсэн
	20	8947 X 8951 X	"Сэлэнгэминералс" ХХК	14520	2004.12.14	батлуулаагүй	ирүүлээгүй	Шинэчлэн бүртгүүлсэн
9 Сүхбаатар аймаг. Төмөртийн овооны цайрын орд								
	21	9766 X	"Цайртминерал" ХХК	634	2005.05.06	батлуулаагүй	ирүүлээгүй	Шинэчлэн бүртгүүлсэн

СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АШИГТ МАЛТМАЛЫН ОРДОД
АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
2006 ОНЫ НӨӨЦ АШИГЛАЛТЫН ТӨЛБӨРИЙН ТООЦОО

(сая төгрөгөөр)

Д/д	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн				Борлуулалт		Нөөц ашигласны төлбөр төлөлт								
	Дугаар	Эзэмшигч хуулийн этгээдийн нэр	Талбайн хэмжээ (га)	Олгосон огноо	Тоо хэмжээ (мян.тн)	Үнийн дүн	Ногдуулалт 2.5%	Ногдуулалт 5%	Нийт ногдуулалт	Тогтвортой байдлын гэрээгээр хөнгөлөлт	Төлөлт	НӨАТ-ын буцаан олголтоор суутгасан	Өмнөх оны үлдэгдэл (+,-)	Тайлант оны зөрүү (+,-)	ҮТЕГ
1	011А	"Эрдэнэт" УУГ	2552	1996.04.06	зэс-534.3 мол-3.29	817259.8	13722.1	13418.7	27140.8		21604.0		-4046.8	-9583.6	27140.8
2	287А;11945А	"Тавантолгойн уурхай" ХК	169	1995.09.08	787.3	29631.0	448.5	693.2	1141.7	0.0	1043.4		-3.5	-101.8	1056.1
3	227А-6ш	"Чинхуа-МАК Нарийн сухайт" ХХК	1229	1995.10.08	1548.6	31777.5	553.4	482.0	1035.4	241.0	754.2		7.1	-33.1	754.2
4	901А	"Шивээ-Овоо" ХК	91	1995.10.08	1306.8	9825.9	245.6		245.6		275.6		-30.0	0.0	245.6
5	1371А	"Багануур" ХК	1445	1998.10.09	2760.9	31934.1	798.4		798.4		859.5		-35.0	26.1	798.4
6	939А	"Төмөртэй хүдэр" ХХК	1200	1998 он	179.7	7623.7	190.6		190.6	0.0	120.0	0.0	0.0	-70.6	
7	198А:15ш	"Бороогоулд" ХХК	6525.1	1997.06.21	А-8756.2 М-1244.6	201313.1	3198.7	3668.3	6867.0	1834.15	3583.0	1449.8		0.1	5032.8
8	723А	"Цайртминерал" ХХК	38	1997.08.13	93.2	105508.7	1560.0	2155.5	3715.5	1077.75	2618.5		-150.0	-169.3	2618.5
		ДҮН				1234873.8	20717.2	20417.7	41135.0	3152.9	30858.2	1449.8	-4258.2	-9932.1	37646.4

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2007 оны дугаар тушаалын хавсралт

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн
этгээдийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын төлбөр, зөрчлийн жагсаалт

Байгууллагын нэр	Төлбөр хариуцагчийн		Төлбөр, зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын дугаар	Төлбөрийн дүн	Зөрчлийн дүн	Үүнээс:		Тайлбар
	Нэр	Албан тушаал					Улсын төсөвт	Орон нутгийн төсөвт	
Цайрт минерал ХХК	С.Хосбаяр	УБ дахь салбарын захирал	Гадаад иргэдийн ажлын байрны төлбөр /төгрөг/	01	111280800.00			111280800.00	Аудитын хугацаанд Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын ОНО-т төлсөн
Монголын алт-МАК ХХК	Д.Дашзэвэг	Дэд ерөнхийлөгч	Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын дутуу /төгрөг/	02	36841800.00		36841800.00		
Чинхуа-МАК Нарийн сухайт ХХК	Н.Батболд	Дэд захирал	Гадаад иргэдийн ажлын байрны төлбөр /төгрөг/	03	12700000.00			12700000.00	Тайлбартай гарын үсэг зурсан
Актын дүн /төгрөгөөр/					160822600.00		36841800.00	123980800.00	
Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар	Л.Болд	АМГТХЭГ-ын дарга	Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын гэрээг шинэчлэн хийж дутууг төлүүлэх /ам.доллар/	01		434936\$	434936\$		
	Ж.Билигсайхан	АМГТХЭГ-ын Уул уурхайн албаны дарга							
Албан шаардлагын дүн /ам.доллараар/						434936\$	434936\$		



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗРЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
Л.ЖАВЗМАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ САЙД

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
А корпус, Утас: 26-29-81, Факс: 32-25-95,
E-mail: mit@mit.pmis.gov.mn; http://www.mit.pmis.gov.mn

2007.06.14 № 1/1657
танай _____-ны № _____-Т

Тоотын харуу

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хүсэлтээр Үндэсний аудитын газраас Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Холбогдох баримт материал дээр тулгуурласан зөв зүйтэй ажил болсон байна гэж үзэж байна.

Тайлангийн зөвлөмжийн хэсэгт дараах саналтай байна.Үүнд:

1. “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын хил хүрээг геологи-уул уурхайн кадастрын зурагт тусгаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах” ажлын хүрээнд АМГТХЭГ-ын дарга Л.Болдод стратегийн орд бүрээр цогц мэдээлэл бүхий материал бүрдүүлэх талаар үүрэг даалгавар өгч ажиллуулж байгаа бөгөөд ойрын үед энэ цогц мэдээллийг хийж дуусгана.
2. “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордод 18 хуулийн этгээдэд хайгуулын 34 тусгай зөвшөөрөл олгосныг хүчингүй болгох” Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд “2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн ордод хайгуулын тусгай зөвшөөрөл /лиценз/ авсан этгээд өргөдөл гаргавал шинэ хуулийн дагуу түүнд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоно” гэж заасан байгаа өөрөөр хэлбэл хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрөө хүсэлт гаргавал ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой юм. Гэхдээ дээрх 34 тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг судалж, шалгаж байна.
3. “Хууль зөрчиж Энержиресурс ХХК, Дайцүки ХХК-нд олгосон ашиглалтын тусгай зөвшөөрлийг хянан үзэж, зохих журмын дагуу шийдвэрлэх” Энержиресурс ХХК, Дайцүки ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг дахин хянаж тодохой арга хэмжээ авна.
4. “Улсын төсвөөс хайгуулын ажилд гаргасан зардлыг нөхөн төлөх гэрээг холбогдох компаниудтай байгуулж, төлүүлэх”, “Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журам”-ыг Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор шинэчлэн тогтоосон дээрх журмын дагуу аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд тайлангийн төсөлд дурдсан зөрчил илэрсэн аж ахуйн нэгжүүдийн талаар тодорхой арга хэмжээ авна.

5. “Төмөртийн овооны цайрын ордын хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийг Засгийн газрын 1997 оны 234 дүгээр тогтоолын дагуу тогтоож, Цайрт минерал компанитай нөхөн төлбөрийн гэрээг шинэчлэн байгуулах” Төмөртийн овооны цайрын ордын хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийг дахин нягталж холбогдох арга хэмжээг авна.
6. “Тусгай зөвшөөрөл олгох, хугацааг нь сунгахад тавих хяналтыг сайжруулж, төлөвлөгөө, тайлан ирүүлэхгүй, үйл ажиллагаа явуулахгүй байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хуулийн дагуу хариуцлага тооцох” гэсэн зөвлөмжийн мөрөөр Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу тодорхой арга хэмжээг зохион байгуулна.

Цаашид Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.



Ц.ДАВААДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**УЛСЫН МЭРТЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН ГАЗАР**

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

Барилгачдын талбай 13. Утас: 26-36-58,

Факс: 976-51-26-34-58,

E-mail: state_sp_su@mbox.mn

2007.06.14

№

9/2179

танай

-ны №

-т

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗАРТ**

Танай газраас Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг уншиж танилцлаа.

Тайланд тусгагдсан зөрчилтэй асуудлуудыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхэд хамтран ажиллах саналтай байна.

Тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно.



ДЭД ДАРГА

Ж.ЭНХБАЯР



**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ**

210620а Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44,
Засгийн газрын III байр, Утас: 32-32-73, Факс: 32-14-01
E-mail: monenv@mail.mn

2007.06.12 № 7/1819

танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танай газрын 2007 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 3/227 тоот албан бичгээр ирүүлсэн УИХ-ын Эдийн засгийн байнгийн хорооны хүсэлтээр Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус яамны зүгээс тусгайлан өгөх саналгүй болно.

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
ГАЗРЫН ДАРГА *Ц.Банзрагч* Ц.БАНЗРАГЧ





МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2007 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасны дагуу аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав.Аудитын тайланг Улсын Их Хурлын Эдийн засгийн Байнгын хороо, Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд, Үйлдвэр худалдааны сайд Ц.Даваадорж, Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд У.Хүрэлсүх, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга Л.Болд нарт хүргүүлсүгэй.

Дөрөв.Аудитын тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2007 оны 10 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Үйлдвэр худалдааны сайд Ц.Даваадорж, Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд У.Хүрэлсүх, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга Л.Болд нарт зөвлөсүгэй.

Тав.Аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хоёрдугаар газрын захирал О.Мэндбаярт даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

tushaal
070129

Монгол Улсын Ерөнхий аудиторын
 2007 оны 45 дугаар тушаалын хавсралт
 Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн
 этгээдийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын төлбөр, зөрчлийн жагсаалт

Байгууллагын нэр	Төлбөр харивуулагчийн нэр		Төлбөр, зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын дугаар	Төлбөрийн дүн	Зөрчлийн дүн	Үүнээс:		Тайлбар
	Нэр	Албан тушаал					Улсын төсөвт	Орон нутгийн төсөвт	
Цайрт минерал ХХК	С.Хообаар	УБ дахь салбарын захирал	Гадаад иргэдийн ажлын байрны төлбөр /төгрөг/	01	111280800.00			111280800.00	Аудитын хугацаанд Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын ОНО-т төлсөн
Монголын алт-МАК ХХК	Д.Дашзэвэг	Дэд ерөнхийлөгч	Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын дутуу /төгрөг/	02	36841800.00		36841800.00		
Чинхуа-МАК Нарийн сухайт ХХК	Н.Батболд	Дэд захирал	Гадаад иргэдийн ажлын байрны төлбөр /төгрөг/	03	12700000.00			12700000.00	Тайлбартай гарын үсэг зурсан
Ажлын дүн /төгрөгөөр/					160822600.00		36841800.00	123980800.00	
Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар	Л.Болд	АМГТХЭГ-ын дарга	Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын гэрээг шинэчлэн хийж дутуу төлүүлэх /ам.доллар/	01		434936\$	434936\$		
		Ж.Билигсайхан	АМГТХЭГ-ын Уул уурхайн албаны дарга			434936\$	434936\$		
Албан шаардлагын дүн /ам.доллараар/									